



АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны
дугаар сарын 2-ны өдрийн 4/2025 дугаар тушаалын
1-дүгээр хаворалт



№ 6.11. ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:3

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалтын удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт эхэлсэн огноо:...../...../.....

Хяналт шалгалт дууссан огноо:...../...../.....

Шаардлага хангасан
асуултын тоо:

Хууль сахин
мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй
нийт оноо:

Эрсдэл үүсэх
магадлалын хувь:

Эрсдэл үүсэх
магадлал

II. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуумж	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1	2	3	4	5	6	
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА						
1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг	Жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй. /Техник, технологийн дүгнэлт/				
2	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх хэсэг	Байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолбор нь холбогдох норм, дүрэм, стандартын шаардлага хангасан эсэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас техник, технологийн дүгнэлт гаргуулсан	0	15		
3	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалт	Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар боловсруулж, улсын экспертизийн хяналт хийлгэсэн зураг, төслийн дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллагаар угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн	0	15		

4	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалт	Шатахуун түгээх станцын зориулалтын газар эзэмших зөвшөөрөлтэй.	0	15		
5	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6 дахь заалт	Барилга байгууламжийг ашиглалтад оруулсан комиссын акт, дүгнэлт, протоколтой	0	15		
6	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн үйл ажиллагааны аргачлал MNS 4633-2006 стандартын 3 дугаар зүйл	Технологи үйл ажиллагаанд газрын тосны мэргэжлийн дээд болон тусгай дунд, мэргэжлийн сургууль, газрын тосны мэргэжил олгох сургалт төгссөн, хэмжилт тооцоололтын ажлыг бие дааж гүйцэтгэх чадвар бүхий хүнийг ажиллуулдаг	0	15		
7	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалт	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан	0	15		
8	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй, түүний дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг	0	10		
ТЕХНИКИЙН БҮРЭН БҮТЭН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ						
9	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дэх хэсэг	Шатахуун хадгалах сав бүрийг улсын бүртгэлд бүртгүүлж техникийн паспорт авсан, баяжилт хөтлөлт хийдэг	0	5		
10	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9.3.2, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14.3 дахь заалт	Чанарын хувьд олон улсын стандартад нийцсэн чанарын баталгаатай бүтээгдэхүүн худалдаалдаг.	0	10		
11	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 10.1.7 дахь заалт	Шатахуун хадгалах савны ашиглалтын нөөцөд /суурилуулснаас хойш 10 жилийн дараа 5 жил тутам/ итгэмжлэгдсэн байгууллагаар сорилт хийлгэж баталгаажуулсан	0	15		
12	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 19.7 дахь заалт	Аянга зайлуулагч, тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлж акт үйлдэн баталгаажуулсан	0	10		
13	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 4.6 дахь заалт	ШТС-ын эдэлбэр газар стандартын шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй	0	10		
14	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 5.1 дэх заалт	ШТС-ын зам талбай нь нийтийн зориулалтын бусад замаас тусдаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саадгүй, гадаргуугийн налуу нь холбогдох норм, дүрмийн хэмжээнээс илүүгүй байхаас гадна ослын үед тээврийн хэрэгсэл саадгүйгээр гарах, гал унтраах, аврах ажиллагааны техник хэрэгсэл хүрэлцэн очих, аврах ажиллагаа явуулах боломж нөхцлийг хангасан	0	10		
15	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS	ШТС-ын шатахуун сав, тоног төхөөрөмж, барилга	0	10		

	4628:2013 стандартын 5.2 дахь заалт	байгууламжид хурын ус орохоос хамгаалагдсан, зам талбайд ус тогтохооргүй хийцтэй				
16	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 7.3 дахь заалт	Түгээх талбай нь шатахууны үйлчлэлд тэсвэртэй, түүнийг хөрсөнд нэвчүүлдэггүй, шингээдэггүй шинж чанар бүхий хийцтэй	0	10		
17	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 9.4 дэх заалт	ШТС-ын удирдлагын байрнаас цэнэглэх үйл ажиллагаанд хяналт тавих бололцоотой	0	10		
18	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 9.5 дахь заалт	ШТС-ын удирдлагын болон нэмэгдэл үйлчилгээний байрны шалны түвшин нь буулгах болон түгээх талбайн түвшингөөс өндөр түвшинд байрласан	0	10		
19	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 10.1.4 дэх заалт	Хадгалах савыг стандарт, нормын дагуу аюулгүйн зай хэмжээг баримтлан суурилуулсан	0	10		
20	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 10.2.6	Газар доорх сав нь тоноглолуудыг хамгаалах, шатахуун хэмжилт хийхэд зориулсан, хур тунадас, зам талбайн болон гадаргын ус орохооргүй хийцтэй, засвар үйлчилгээ хийх боломж бүхий худагтай	0	10		
21	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 10.2.7 дахь заалт	Хот, хүн ам нягт суурьшсан, хөрс, хөрсний ус бохирдох эрсдэл бүхий газар байрлах далд савтай ШТС-д давхар ханатай сав суурилуулж хана хоорондын орон зайн битүүмжлэлийг хянах хэрэгслээр тоноглосон	0	10		
22	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 10.3.2 дахь заалт	Газар дээрх савыг газар хөдлөлт, үер хүчтэй салхи зэрэг байгалийн нөлөөлөл, тээврийн хэрэгслийн мөргөлтөөс найдвартайгаар хамгаалан бэхэлж хооронд нь 1м-ээс багагүй зайтайгаар суурилуулсан	0	10		
23	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 11.1 дэх заалт	Сав бүр бүрэн тоноглогдсон /Орлого зарлагын хоолой, түвшин хэмжих хэрэгсэл, дээж авах хэрэгсэл, агааржуулах хоолой, амьсгалын хавхлаг, хаалтууд, хэмжилт хийх, дээж авах, саванд орох нээлхийнүүд/	0	10		
24	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 11.5 дахь заалт	Савны амьсгалах хавхлагийн байрлал нь 4м өндөртэй байх ба түүнээс гарч буй шатахууны уур барилга байгууламжид орохгүй, ямар нэг газарт хуримтлагдахгүй нөхцлийг хангасан	0	10		
25	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 12.2 дахь заалт	Суурин ШТС-д түгээгүүрүүдийг арал дээр эсхүл тээврийн хэрэгсэл мөргөхөөс найдвартай хамгаалагдсан суурин дээр аюулгүйн зай хэмжээг баримтлан үйлвэрлэгчийн гаргасан зааврын дагуу суурилуулсан	0	15		

26	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 12.13 дахь заалт	Түгээгүүрийг тээврийн хэрэгсэл мөргөх, уян хоолойноос чирэх тохиолдолд эвдрэх, шатахуун асгахаас хамгаалсан аюулгүйн таслагчтай	0	10		
27	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 14.4 дэх заалт	Түгээгүүрийн арлын металл хийцүүдийг газардуулгын сүлжээтэй холбосон	0	10		
28	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 16.3 дахь заалт	Технологийн худаг нь гадаргын болон хөрсний ус орохооргүй хийцтэй, хоолойн оруулгуудыг худагт ус орох, шатахуун гадагш нэвчихээс хамгаалах зориулалтын, механик үйлчлэлээс хамгаалагдсан битүүмжлэх хэрэгслээр тоногдсон	0	10		
29	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 17.1 дэх заалт	ШТС-ын саванд шатахууныг хүлээн авах үйл ажиллагаанд зориулалтын буулгах хэрэгслийг ашигладаг	0	10		
30	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 17.4 дэх заалт	Ил байрласан буулгах худаг нь шатахуун буулгах автоцистерний зогсох талбайн дэргэд тусдаа байрласан бөгөөд тээврийн хэрэгслийн мөргөлт, бусад механик гэмтлээс хамгаалагдсан	0	10		
31	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 17.5 дахь заалт	ШТС-ын буулгах хоолой, холбогчууд нь битүүмжлэгдсэн, түргэн холбох, салгах боломжтой шатахуун буулгахаас бусад үед тагтай байх бөгөөд автоцистернд холбох холболт нь резьба холболтгүй	0	10		
32	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 18.1 дэх заалт	ШТС-ын цахилгаан тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь "Цахилгаан байгууламжийн дүрэм" БД 43-101-03, бусад холбогдох дүрэм, журам, норм, энэхүү стандартын шаардлагыг хангасан	0	10		
33	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 18.3 дахь заалт	Технологийн тоног төхөөрөмжийн цахилгаан тэжээлийн холболтыг тэсрэлтээс хамгаалагдсан арга технологиор гүйцэтгэсэн	0	10		
34	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 18.5 дахь заалт	Гэнэтийн ослын үед түгээгүүрүүд, тусдаа байрласан насос, буулгах насосны цахилгаан тэжээл, тэдгээрийн аюулын бүсэд байгаа цахилгаан тоног төхөөрөмжийн тэжээлийг салгах аюулгүйн таслах товчлууртай бөгөөд товчлуурыг түгээгчийн ерөөнд эсвэл түгээгүүр насосноос 7-30 метрийн зайд, хүрэхэд хялбар газар байрлуулж, таних тэмдэг тавьсан	0	10		
35	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 19.1 дэх заалт	ШТС-ын технологийн болон цахилгаан тоног төхөөрөмжүүдийг холбогдох стандарт, норм, үйлдвэрлэгчийн зааврын дагуу газардуулсан. Цахилгаан	0	10		

		хөдөлгүүрт хамгаалалтын газардуулга хийсэн.				
36	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 19.3 дахь заалт	Шатахуун буулгаж байгаа автоцистернийг газардуулах хэрэгсэлтэй.	0	10		
37	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 19.4 дэх заалт	ШТС-ын удирдлагын байр түүний орчинд байгаа металл дээвэр бүхий байгууламжууд, саравч, үнийн самбар зэрэг металл хийцүүдийг газардуулгад холбосон.	0	10		
38	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 6.17, Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 6.2 дахь заалт	Буулгах талбай нь шатахууны үйлчлэлд тэсвэртэй, түүнийг хөрсөнд нэвчүүлдэггүй, шингээдэггүй шинж чанар бүхий хийцтэй бөгөөд талбай нь 150 мм-ээс багагүй өндөртэй хашлагаар хүрээлэгдсэн, автоцистерний буулгах хоолойн битүүмжлэл алдагдахад буулгах талбайд асгарсан шатахууныг ослын сав руу урсгаж оруулах зориулалттай хоолойг төлөвлөсөн.	0	10		
39	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм БНБД 21-07-14-ийн 7.23 дахь заалт	Технологийн системийн шатахуун хүлээн авах, хадгалах, түгээх, суллах үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжүүд (тээврийн хэрэгслийн түлшний банкыг дүүргэхээс бусад) бүгд битүүмжлэгдсэн.	0	10		
40	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 5.5 дахь заалт	“Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04-ийн 1.5 заалт дах хотын зэрэглэлтэй суурин газар болон тэдгээртэй адилтгах хүн амын нягтаршил ихтэй сууринд байрлаж буй ШТС-д газар дээрх сав ашиглаагүй. /зөвхөн байгууллагын хэрэглээний ШТС-д газар дээрх сав ашиглаж болно/	0	10		
41	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 6.14 дэх заалт	Газар дээрх сав нь дан ханатай тохиолдолд сав тус бүр, эсхүл хэсэг бүлэг савны эргэн тойронд битүү хүрээлсэн, асгарсан шингэний гидростатик даралтыг тэсвэрлэхүйц бат бэх 0.5 м-ээс намгүй, түүний үүсч буй дотоод орон зайн багтаамж нь хамгийн том багтаамжтай савны багтаамжаас багагүй шороон далан эсвэл шатдаггүй материалаар хийсэн хязгаарлах хана байгуулсан.	0	10		
42	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 5.3 дахь заалт	ШТС-д ослын улмаас шатахуун асгарсан тохиолдолд ШТС-ын эзэмшлийн газраас гадагш тархахгүй байхаар төлөвлөсөн бөгөөд ШТС-ын зам талбайн орц, гарц дээр 0.2 метрээс багагүй өндөртэй өндөрлөгөө, мөн шатахуунаар бохирдсон гадаргуугийн хур тундасыг	0	10		

		зайлуулах сувгийг ШТС-ын цэвэрлэх байгууламжтай холбож төлөвлөсөн.				
43	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 6.22 дахь заалт	ШТС нь "Барилга, байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар" БД 43-103-08-ын 2.1 дүгээр хүснэгтэд заасны дагуу III ангиллаас багагүй ангиллын шаардлага хангасан аянга хамгаалагчтай.	0	10		
44	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 10.5 дахь заалт	Шатахуун түгээх станцын машин угаах байрнаас бусад ерөө тасалгаанууд галын автомат дохиоллын системтэй.	0	10		
45	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 5.13 дахь заалт	Шатахуун түгээх станцын эзэмшлийн талбай дах тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь нэг чиглэлтэй байх, орц ба гарцыг тодорхой тогтоосон.	0	10		
46	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 6.8 дахь заалт	Шатахуун түгээх станцын барилгад гал гарах болон Згагнуурын ажил хийхэд зориулсан байр төлөвлөж ашиглаагүй.	0	10		
47	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 6.24 дэх заалт	Шатахуун түгээх станцад цахилгаан дамжуулах агаарын шугам төлөвлөж ашиглаагүй.	0	10		
ГАЛЫН АЮУЛГҮЙН ЗАЙ ХЭМЖЭЭ /М/						
48	Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм. БНБД 21-07-14-ийн 5 дахь хэсэг, Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 3.6, 10.1.4 дэх заалт	ШТС-д хамаарагдахгүй барилга байгууламж хүртэлх зөвшөөрөгдөх зай хэмжээг хангасан	0	15		
49	Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4628:2013 стандартын 3.6, 10.1.4 дэх заалт	ШТС-ийн технологийн барилга байгууламж хоорондын зөвшөөрөгдөх зай хэмжээг хангасан	0	15		
ДОТООД ХЯНАЛТ						
50	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, Газрын хэвлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам	Удирдамж, хөтөлбөртэй	0	15		
51		Хяналт хийсэн	0	10		
52		Авсан арга хэмжээ, хүрсэн үр дүн	0	5		
НИЙТ ОНОО			0	555		

III. ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

.....

.....

БИЕЛЭЛТ:

.....

БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:

.....

IV. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

.....

.....

БИЕЛЭЛТ:

.....

ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:

.....

Их эрсдэлтэй >=50%
 Дунд эрсдэлтэй 30%-49%
 Бага эрсдэлтэй <=29%